

РЭНЦЭНДОРЖИЙН “ТАЙЛБАРТАЙ ДАСГАЛЫН АРГА”, ЛУВСАНЦЭРЭНГИЙН “САЙХАН БИЧҮҮЛЖ СУРГАХ АРГА”-ЫГ ЭЗЭМШИХ АРГА ЗҮЙ

Ц.Оюун, Л.Цэрэнчимэд, МУБИС

Abstract

Nowadays it is essential for young people to be able to explain something logically and coherently, think creatively, write legibly and correctly, and to enrich those skills in their activities. In the national curriculum of a 12-year secondary education of Mongolia, the aims and objectives of the Mongolian Language as a subject are stated: Students are expected to acquire a profound knowledge in terms of native language; to analyze and comprehend any type of writing; to be able to seek; to learn creatively and solve the causes and matters of the main or inferior issues; and finally to express their thoughts clearly and legibly in their writing.

‘Tasks with explanation’ is one of the most appropriate and creative learning approaches to be carried out to fulfil the goals and aims above. Using this method in language training helped student achieve great success in developing students’ skills to analyze and interpret the matters in the 80s and 90s.

The use of this methodology with the same goals and aims could be vital not only in Mongolian Language classes but also in other classes. For this reason, this paper introduces the method called ‘Tasks with explanation’, which was created by G.Rentsendorj (State Honored Teacher) and widely popularized in the 80s and 90s.

Furthermore, today the skills to write legibly, express oneself coherently orally and in written forms is highly valued. This was developed in the 80s and 90s through the method called “Approach to compose and write legibly” by B.Luvsantseren, a Mongolian language teacher from the secondary school of Dashbalbar, in Dornod province. That approach was a skill that must be developed at all stages of schooling within the country. Related to the goals and aims of the national curriculum, this method is intended to be used by specialists, methodologists and teachers of the Mongolian Language.

Түлхүүр үг

Тайлбартай дасгал, тайлбарлах дасгалын ялгаа, зөв сайхан бичүүлэх арга зүй

Удиртгал

Эдгээр арга зүй чухал болох тухай

Өнөөдөр хүүхэд залуусын хэлний боловсролд аливааг тайлбарлан ярих, бүтээлчээр сэтгэн бодож түүнийгээ ажил үйлстээ баяжуулан хэрэглэх үйл чухал болжээ. Монгол хэлний ерөнхий боловсролын 12 жилийн үндэсний хөтөлбөрт: “Сурагчид эх хэлний баялаг сангаас эзэмшин, аливаа бичвэрийг задлан шинжилж ойлгох, гол ба гол бус асуудлын учир шалтгаан, мөн чанарыг эрж хайж бүтээлчээр судлан, шийдвэрлэх чадвар, дадлагатай болох” тухай зорилго, зорилт дэвшүүлсэн байна.

1. Энэхүү зорилгыг хэрэгжүүлэхэд хамгийн ихээр хэрэглэж болох бүтээлч суралцахуйн нэг арга нь “Тайлбартай дасгалын арга” юм. Энэ аргаар 1980-1990-ээд оны монгол хэлний сургалтаар хүүхдийг хөгжүүлж, яриа, бичгийн чадвар, учирлан ойлгож, мөн чанарыг задлан шинжилж, тайлбарлан ярих чадвартай болгож, ихээхэн амжилт олж байв.

Иймд зорилго, зорилт ижил энэ арга зүйг өнөөдөр монгол хэлний гэлтгүй, ямар ч хичээлд хэрэглэх нь чухал байна. Энэ үүднээс, Монгол Улсын гавьяат багш, 1980-1990-ээд оны “Шинийг санаачлагч, бүтээлч багш Гонжавын Рэнцэндоржийн тэр үед алдаршсан “Тайлбартай дасгалын арга”-ыг арга зүйчлэн танилцуулж байна.

Энэ арга нь зөвхөн монгол хэлний хичээлд ч биш, математик, физик, хими зэрэг задлан шинжилгээ хийдэг аливаа хичээл бүхэнд хэрэглэж болох түгээмэл хэрэглээтэй арга юм. Энэ аргыг ОХУ (хуучнаар ЗХУ)-ын Липецкийн багш нараас үүсгэл эхлэлтэйгээр 1960-аад оны оросын бүх новатор багш идэвхтэй хэрэглэж байсан туршлага бий. Энэ туршлагын зарчмыг Ш.Гаадамба орчуулан, Г.Рэнцэндорж багш монгол хөрсөнд буулган, шинэчилж боловсруулсан түүхтэй.

Манай улсад мөн тэр үеэс Рэнцэндорж багш анхлан хэрэглэж монгол хэлний сургалтын

* ✉ oyun_tserentsol@yahoo.com

арга зүйг шинэчлэх, хөгжүүлэхэд их хувь нэмэр оруулсан хүн. Ийм учраас шинийг санаачлагч буюу новатор багш гэж 1980-аад оны үед нэрлэж байсан байна. Тэр цагт энэ аргыг монгол хэлний бүх багш мэддэг, 80-аад хувь нь сургалтдаа хэрэглэж байсан судалгааны дүн бий. Энэ хэрээр монгол хэлний сургалт, арга зүй тухайн 20-иод жилд ихээхэн амжилт олж байжээ.

2.Өнөөдөр зөв сайхан бичиж, оновчтой найруулан илтгэж, бичих чадвар хамгийн эрхэмд тооцогдох болов. Энэ чиглэлээр мөн 1980-1990-ээд оны үед ихээхэн амжилт олж, улсын хэмжээнд заавал дэлгэрүүлэх тэргүүн туршлагын нэг болж байсан Дорнод аймгийн Дашбалбар сумын 8 жилийн дунд сургуулийн монгол хэлний багш Б.Лувсанцэрэнгийн “Зөв, сайхан бичиж, найруулах туршлага”-ыг дээрх үндэсний хөтөлбөрийн зорилго, зорилтыг хэрэгжүүлэх арга зүйн хүрээнд зориудаар, монгол хэлний мэргэжилтэн, арга зүйч, багш нарт хүргэхийг чухалчилж байна.

Судалгааны арга зүй

1980-аад оны үед анхны “Шинийг санаачлагч, бүтээлч багш” новатор гэсэн албан ёсны алдар цолтой 7 хүн байсан нь Булганы Рэнцэндорж, Говь-Алтайн О. Лхаминдаваа, Дорнодын Б.Лувсанцэрэн, Увсын Г.Гомбожав, Ховдын Бадамсэд, Завханы Д.Дагва, Нийслэлийн 1 дүгээр сургуулийн хичээлийн эрхлэгч Цэрэннадмид гэсэн 7 хүн байсныг боловсролын түүх мартаж болохгүй юм. Тэр 7 хүний тэргүүн туршлагыг улсын хэмжээнд нэвтрүүлэхээр яамнаас сайдын албан захидал, тушаал гаргаж байв. Энэ үе буюу 1973-1990 онд ЕБС-ийн бүтэц “3+5+2” жилийн сургалттай байсан ба бага анги 3 дугаар ангиар төгсөж, 4 дүгээр ангиас дунд анги эхэлдэг байсан билээ. Энэ бүхнийг арга зүй талаас судлан үзсэн олон судалгааны нэг нь бидний энэ ажиглалт дүгнэлт юм.

Бид энэ чиглэлээр хэдэн жилийн өмнө “Тайлбартай дасгал” хэмээх сургалтын баримтат 2 бүлэг киног “Кино үйлдвэр”-тэй хамтран гаргаж олон удаа сурталчилсан билээ. Мөн Б.Лувсанцэрэн багшийн сайхан бичүүлдэг арга туршлагыг “Боловсролын яам”, “Боловсролын хүрээлэн”-гийн шугамаар сурталчлан дэлгэрүүлэх ажилд оролцож байсан юм. Энэхүү өгүүлэлд эдгээр арга, туршлагыг дунд сургуульд нэвтрүүлэн түгээх зорилгоор арга зүйн зөвлөмж байдлаар үзүүлж байна.

Арга зүйн анхдагч, бүтээлч хоёр товч багшийн танилцуулга

2.1. “Тайлбартай дасгалын Рэнцэндорж” хэмээх нэр алдар

Монгол Улсын гавьяат багш, “Анхны шинийг санаачлагч, бүтээлч багш” (новатор), монгол хэлний багш Гонжавын Рэнцэндорж бол “Булганы Рэнцэндорж” хэмээн алдаршсан хүн. Тэрээр төрөлх сум Хишиг-Өндөрийн сургуульд олны хүртээл болгосон баялаг түүхтэй. Энэ аргыг сайн хэрэгжүүлж үнэлэгдэхүйц үр дүнд хүрсэн гавьяатай багш нар бол Булган аймгийн багш Д.Цэдэв (ажиллаж байхдаа “Тайлбартай дасгалын арга”-аа туршин дэлгэрүүлсэн), Бадам, Улаанбаатар хотын бага ангийн багш Оюунханд нарын зэрэг олон хүн бий. Хэрэв манай дунд сургуулийн багш нар энэ туршлагын залгамж, өвийг нүдээр харж судална гэвэл, Булганы Хишиг-Өндөр сумын 10 жилийн сургуульд туршлага судлах бүрэн боломжтой. Тэнд Рэнцэндорж багшийн нэрэмжит танхим ч бий. Тус сургууль энэ туршлагаа сайн үргэлжлүүлэн хэрэгжүүлж буй сургууль юм.

Энэ багш юугаараа алдартай вэ?

Сургалтыг шинжлэх ухааны үндэстэй зохион байгуулж, сурагчдын эрэл хайлтаар ухаарч ойлгосон мэдлэгийг бүтээлч чадвар дадлага болгон хөгжүүлэх аргыг шинээр санаачлан “Тайлбартай дасгалын арга” хэмээх шинэ арга зүй, технологийг улсын хэмжээнд нэвтрүүлсэн бүтээлч багш юм. Энэ арга нь сурагч асуудлын учир шалтгааныг “сэтгэх- тайлбарлах- бичих” гурван гол үйлийн зэрэгцэл дээр бусдад түгээж чаддаг болгодог, мэдлэг бүтээх-түгээх- баталж нотлох арга зүй технологи болно.

“Тайлбартай дасгалын арга”-ын тухайд

Энэ аргын давуу тал их билээ. Одоогийн монгол хэлний сургалтын зорилт болсон:

- Судлах замаар мэдээлэл, өгөгдөлтэй ажиллах, боловсруулан хүлээж авах
- Унших, бичих, ярих, сонсох, сэтгэх аман ба бичгийн харилцах чадвараа хөгжүүлэх
- Хэлний нэр томъёог хэрэглэх
- Бүтээлчээр сэтгэх, задлан шинжлэх
- Мэдлэгээ түгээх, хуваалцах зэрэг энэ үйлүүд “Тайлбартай дасгалын арга”-д бүгд агуулагдаж байдаг.

Тодруулбал:

- Тухайн асуудлын учир шалтгааныг ухааран ойлгох
- Задлан шинжлэх аргыг түргэн хэрэглэхэд

суралцах

- Суралцагч төвтэй
- Бүх хүүхдийн оролцоог бага цагт тэгш хангадаг
- Үйл ажиллагааны нэгдсэн зарчим, өөрийн гэсэн бүтэц дэс дараалал, дэгтэй
- Асуудлыг дэвшүүлэн тавьж хүүхэд бүр ухааран эрж хайж, хэрэглэж, туршиж, итгэлтэй батлан тайлбарладаг
- Даалгаврын гүйцэтгэл бүхэнд ил тод, хүүхэд бүрт хүртээмжтэй ноогддог, оролцоогүй хүүхэд 45 минутад нэг ч үлддэггүй
- Ноогдсон үүргээ хүүхэд унших-бичих-сэтгэх-түүнийгээ бусдад уран тодоор тайлбарлах- өөрийнхээ яриаг сонсох гэсэн мэдрэхүйн 5 үйлийг цогц, нэг хугацаанд давхцуулан цогцоор гүйцэтгэдэг. Энэ нь суралцагчийг бүх талаар тэгш хөгжүүлдэг “1 дүгээрт давуу, 2 дугаарт ч давуу, 3 дугаарт мөн л давуу арга юм.”
- Ингэснээр хүүхэд хамт олныхоо өмнө хариуцлага хүлээх
- Бусдыгаа сонсон хүлээж авах, хүүхэд хүүхдийнхээ хэлээр мэдлэг туршлагыг нь эзэмших
- Хэн нь ч хоцрохгүй суралцах, тэгш хөгжих, хэл яриагаа хөгжүүлэх бололцоо олгодог бүтээлч арга болно.

2.2 “Сайхан бичгийн Лувсанцэрэн” хэмээх нэр алдар

Монгол Улсад 1980-аас 1989 оны үед ид хүчээ авч, дунд сургуулийн багш нарын дунд алдаршиж орон даяар туршлагыг нь эзэмшихээр оройлж явсан анхны 7 багшийн нэг явсан Новатор буюу Улсын шинийг санаачлагч, бүтээлч багш Бүдийн Лувсанцэрэн Дорнод аймгийн Дашбалбар сумын 8 жилийн сургуулийн монгол хэлний багш хүн.

Энэ багш юугаараа алдартай вэ?

Сурагчдад эх хэлний яруу тансаг сангаас эзэмшүүлэн, уран сайхан найруулан зөв, сайхан бичүүлэх арга ухааныг эзэмшсэнээрээ нэрд гарсан арга зүйч хүн юм. Б. Лувсанцэрэн багш өөрөө, самбар болоод сурагчдын дэвтэрт үлгэр жишээ, нямбай бичдэг, үйлдлээрээ дагуулан сургаж ирсэн монгол уламжлалт технологи мөн.

Энэ багшийн бүтээлч арга барилыг сурталчлан бичсэн хүмүүс нь тэр үеийн Сурган хүмүүжүүлэх ухааны хүрээлэнгийн “Багш нарын мэргэжил дээшлүүлэх салбар”-ын эрхлэгч Ш.Шагдар, Ардын боловсролын

яамны сайд Б.Даваасүрэн, УБ хотын Сургалт заах аргын кабинетын монгол хэлний заах аргач Т.Гомбосүрэн, СХУХ-ийн секторын эрхлэгч Д.Нацагдорж, Ц.Өлзийхутаг, К.Кабидаш зэрэг нарийн мэргэжлийн нэртэй хүмүүс байв.

3. Анги нийтээрээ зөв, сайхан бичихэд сургах арга ба түүний арга зүй

Энэ аргад баримтлах зарчим нь

Уйгагүй, шаргуу хөдөлмөр. Зөв, сайхан бичих зорилгыг анги, сургууль хамт олны үйлс, хэрэгцээ болгох, сурагчдад тэр хэрэгцээг нь ухааруулах явдал юм.

Сайхан бичүүлж сургах аргын тухайд

Ингэж бүгдийг жигд сайхан бичүүлж сургахын өмнө бичлэг, үсгийн тиг зурлага, үсгийн налалтын градус, өндөр нам нь ямар байх, үг хоорондын болон үсэг хоорондын зай ямар байх зэргийг зураглан бичиж мэдүүлдэг. Бичих дэвтрийн хуудасны цаана зөв налалттай элемент бүхий цаас тавиулан хэвштэл бичүүлдэг байна.

Шалгахдаа градустай шугамаар хэмжин хэмжээг засаж сургадаг аж. Энэ нь цэвэр бичих шаардлагад нийцэх ёстойг журам дүрмээр нь мэдүүлэх зөөлөн агаад албан арга тул хүүхдүүд тэр дүрмээр бичихийг хичээдэг. Тэгж сайхан бичих хүсэлд аандаа хөтлөгддөг байна. Энэ нь хэд дахин шаардахаас хэн хэнд нь илүү үр дүнтэй арга юм. Ийнхүү алдаа мадаггүй, цэвэр сайхан бичих, бичүүлэх эрмэлзэл нь зөвхөн нэг багшийн биш, бүх мэргэжлийн багшийн үүрэг байж хүүхэд сайхан бичих дадалд тууштай суралцах тул бусад хичээл дээр ч энэ шаардлага хэрэгждэг байжээ. Бүх хичээлийн дэвтрийн бичлэгийг үзэж хянан зөвлөх ажлыг Б. Лувсанцэрэн багш, захирлын зөвшөөрлөөр хийж, зөвлөн бүх нийтийн үйлс болгодог байв. Багш нартаа ч ийм бичлэгийн арга технологийг зааж өгдөг. Хүүхдүүдээр хичээнгүй бичлэгийн дэвтэр нээлгэж өдөр бүр нэг хуудас бичүүлж бичлэг жигдэртэл үргэлжлүүлнэ. Ингэснээр бичүүлж дадуулна.

Үзэг, бэхний өнгө, өтгөн шингэн нөлөөлөх тул түүнийг анги нийтээр нь нэгдмэлээр тохируулан найруулж өгдөг. Эцэг эхэд нь ч аргачлан зааж өгдөг байна. Энэ аргыг өнөөдрийн багш нар сургуульдаа санал тавиад биечлэн хариуцаж, улмаар сургуулийнхаа хэмжээний үйлс болгон уриалж ажиллахад болох билээ.

Алдаагүй зөв бичихэд сургах тухайд

Алдаагүй бичүүлж сургах нь сурагчдын

мэдлэгийг чадвар болгон хувиргах эрхэм зүйл. Үүний тул сурагчид их зүйлийг уншин үгээ нүдлэхээс эхэлнэ. Уншлагыг байнгын хэрэглээ болгохын тулд хурдан унших, бас түүнтэй зэрэгцээ үгнүүдээ нүдлэн тогтоох явдал тул энэ тал руу нь Лувсанцэрэн багш анхаарч хэрхэх аргаа төлөвлөдөг аж. Ийн хурдтай уншилгыг хүүхэд бүр хэрэгцээгээ болгох төдийгүй, ерөөс алдаагүй бичихэд шууд нөлөөлөх зүйл бол байнгын уншлага, унших чадвар хэмээн үзэх болдог байна. Ийм сэтгэлгээг сурагчдад суулгасны дараа, дараах хэд хэдэн алхмыг үргэлжлүүлдэг.

Тухайлбал,

1. Хурдан уншихад сургах арга техникийг зааж эзэмшүүлнэ.
2. Уншсанаа ойлгоход сургана.
3. Уншсан урт үгээ нүдлэн тогтоох ажигч гярхай болон цээжлэх аргад сургана.
4. Бичих явцад нүдлэн тогтоосон үгээ хэрхэн ашиглахыг сануулна.

Эдгээрийг дунд анги гэхгүйгээр заана. Үгийг нүдлэн унших нь дараа хурдан унших суурь болно. Алдаагүй бичихэд гол нөлөөлөх зүйл зөв бичих дүрэм тул бага ангиас нь яаж ажиллах аргыг Лувсанцэрэн багш бага ангийн багш нарт зөвлөн хамтарч ажилладаг байв. Өөрийн хичээл дээр эргэлзээтэй болон дүрэмтэй холбох үг бүр дээр төвлөрөн ажилладаг, алдааг нь хүүхдээр өөрөөр нь олуулна. Хүүхдийн онцлогт тохируулан, алдааг бага ч болов газар ахиулахгүй засаж зөв болгуулах, зөв бичих зүйн тоглоом, үгэн сүлжээ, лото, таавар зэргийг тогтмол хэрэглүүлдэг.

Мөн зөв бичих дүрмээр тайлбарлуулна. Унших чадварыг сайжруулахад байнга анхааран, бүтээлч уншлагын аргыг эзэмшүүлж, ойлгосныг нь дэвтэрт тэмдэглүүлэн багш уншиж тогтмол зөвлөдөг. 4 дүгээр ангиас нь найруулан бичлэгт сургаж эхэлдэг. Тэр үед 4 дүгээр анги дунд ангид тооцогддог байв. Энэ ангиас нь эхлэн чөлөөт тэмдэглэл хөтлүүлж сургахад хүүхэд дуртай хийдэг, хөгждөг байна. 6 дугаар ангиас төлөвлөгөөний дагуу найруулах, зохион бичлэг хийлгэнэ. Энэ мэтээр ажлын хүнд хөнгөн, агуулгын хэмжээг анги ангиар, хүүхдийн чадвар түвшинд тохируулан хүндрүүлдэг байна.

Мөн эдгээр ажлаа тууштай хэрэгжүүлэх зорилгоор хичээлээс гадуур олон ажил зохиодог байна. Тухайлбал, “Сайхан бичигтэн” шалгаруулан, алдаагүй сайхан бичлэгийн үзлэгийг үе үе явуулдаг байна. Тэрчлэн уран зохиолтой нөхөрлүүлэх, хэл яриаг баяжуулах ажлыг дагалдуулан цогц багц ажил болгож авч

явдаг.

Нэрт зохиолчдын төрсөн өдрийг угтсан ажил зохиож, зохиолоос нь унших, хэлэлцэх, товчлол, сэтгэгдэл, зохиомж бичүүлэх, асуулт хариултын хайрцаг аялуулах зэрэг бичих, зохиож боловсруулах олон хэлбэрийн ажил бодож олдог байна. Б. Лувсанцэрэн багшийн үнэлгээний баримтлах систем өөр, онц, сайн, дунд гэсэн л дүнтэй, муу гэхээр үнэлгээ байдаггүй. Багаар, хамтын ил үнэлгээний самбараар тус тусад нь шалган дүн тавьдаг, нэлээд жинтэй даалгаврыг урьд нь боловсруулан өгдөг байжээ.

Ингэснээр, яамны үзлэгт сурагчид нь 100 хувийн амжилт, 92 хувийн онц сайны үзүүлэлттэй үнэлгээ авч байв. Б. Лувсанцэрэн багш энэ аргаа Дорнод аймгийнхаа монгол хэлний багш нарын 60 хувьд эзэмшүүлжээ. Сурагчид нь монгол хэлний хичээлд их дуртай, багшийн жүжиглэн унших, ярих, тоглох чадвар, уран зохиолын зураг зуруулах зэрэг авьяасыг өвлөн эзэмшсэн төдийгүй, хэл бичгийн олимпиадуудад ангиараа олон удаа тэргүүлсэн байна.

Эдгээр амжилтын гол түлхүүрийг судлаачид Б.Лувсанцэрэн багшийн тууштай шаардлагаа урьдчилж боловсруулаад түүнийгээ ойлгуулах тактикийн холбож үздэг. Мөн түүний ажил хэрэгч, уйгагүй, тэвчээрт хөдөлмөрч зан чанар, байнгын хяналт зөвлөгөө бүхий үйл, санаачилга зэргийг олон зүйлээр нотлон бичсэн байдаг. Энэ хүний ажил үйл, туршлагыг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх зорилгоор Дорнод аймгийн БСУГ-аас аймгийн хэмжээнд 9 дүгээр ангиудын дунд массын олимпиадыг зохион явуулсаар 10- гаруй жилийн нүүр үзэж байна. Мөн Дашбалбар сумын ЕБС-ийн бага ангийн багш нарын санаачилгаар сургуулийн хэмжээнд сайхан бичигтэн уралдааныг уламжлал болгон явуулж эхлээд байгаа юм.

Үүний зэрэгцээгээр энэ өгүүллийг бичигчид багш, арга зүйч, дидактикийн багш нартаа дараах зүйлийг нэмж зөвлөе. Энэ бол, хүүхдийг зөв бичих дүрмийн толь ашиглахад сургах, зөв бичгээр уралдаан, тэмцээн, бага олимпиад зохиох, ангийн зөв бичгийн буланд тогтоолгох үгийг бичиж шалган үзэж байх, зөв бичгийн дүрмээр сэдвийн шалгалтыг зориуд авч байх зэрэг ажлыг хийгээд байх аваас зөв бичих ажил саарахгүй, хэрэглээ тогтмолжсоноос хүүхэд мартагнахгүй сайн талтай гэж үзсэн хэрэг юм.

4. Тайлбартай дасгалын арга ба түүний арга зүй

Энэ аргад баримтлах зарчим

- Тайлбартай дасгалын аргыг хичээлийн

шаардлагатай нэгээхэн хэсэгт буюу 10-20 минутын турш хэрэглэнэ.

- Энэ аргаар явуулахад үнэлгээ бүх нийтэд, сурагч өөрт нь ч нээлттэй, ил тод байна.
- Тайлбарлах явц ээлж дараа суудлын эрэмбээр болон нэр цохох тохиолдлын чанартай. Баруун ба зүүн гарын, дүрэмтэй ч цуваагаар, ба эгнээгээр, урдаас хойноос хаанаас ч эхэлж болно..
- Ангийн бүх хүүхдэд сонсогдохоор яруу тод, үг, өгүүлбэр тодорхой, бүрэн бүтэцтэй тайлбарлахыг хүүхэд бүр анхаарах үүрэгтэй.
- Хүүхэд бүрийн дуу анги дүүрэн сонсогдож байхаар тод, цовоо, цэгцтэй байхад багш, хүүхэд нэг бүр анхаарна. Сул дуугаар ярьж, түгдэрч болохгүй. Өөртөө итгэлтэй, шударга, чанга тайлбарлана.

Тайлбартай дасгалын арга технологи, арга зүй

Бодож сэтгэх-тайлбарлан ярих-бичих гурван үйл зэрэг хийгдэж байгаа хөгжүүлэх аргыг “Тайлбартай дасгалын арга” гэнэ. Үүнийг шинжлэх ухааны үндсээр нь “Үндэстэй тайлбарын арга” буюу “Интерпретацийн арга” гэж үзэж болно.

Тайлбарлах дасгал бол уг зүйлийн учрыг зөвхөн тайлбарлаж хэлэх бол, “Тайлбартай дасгалын арга” нь сэтгэнгээ тайлбарлаж бичих явдал тул хоорондоо зарчмын ялгаатай.

Монгол хэлний 1970-1980 –аад оны үеийн нэрт арга зүйч, Сурган хүмүүжүүлэх ухааны хүрээлэнгийн монгол хэлний сургалт хариуцсан эрдэм шинжилгээний ажилтан, эрдэмтэн, зохиолч Ш.Гаадамбын тэмдэглэснээр: “Монгол Улсын гавьяат багш Г.Рэнчиндоржийн хэрэгжүүлж үр дүнд хүрсэн “Тайлбартай дасгалын арга”-ын гол агуулга нь, эл аргаар монгол хэлний хичээлийн үр дүнг сайжруулж, зөв бичих дүрэм, дадлага, хэл зүйн асуудлаар сурагчдын сэтгэн бодохуй, бие даасан үйл ажиллагааг хөгжүүлэн, хэлний үзэгдлийн мөн чанар, хууль жамыг баттай мэдүүлж, тэдэнд, ярих-сонсох-бичих гуравласан дадлагыг төвөггүй эзэмшүүлж чадсан явдал мөн”. Гол нь тухайн ангийн бүх сурагч уг зүйлийг өөрийн болгон ойлгосноо бусдад итгэл үнэмшилтэй, зөв, яруу тодоор тайлбарлан харуулж чаддаг болгосонд байгаа юм. Тэгээд алдаагүй бичиж сайхан эх зохиож сургасан явдал биднийг баярлуулж байдаг.” гэсэн нь энэ аргыг хэрэглэх багш нарын мэдвэл зохих зүйл мөн байна.

“Тайлбартай дасгалын арга”-д сургадаг дэг аргачлал: Хэд хэдэн шатлал буюу алхмаар хэрэгжих тул багш тэвчээртэй, уйгагүй, бас уур

уцааргүй, урьхан харьцах шаардлагатай. Мөн багш тасралтгүй залган тайлбарлуулах зүйлээ урьдчилан сайтар боловсруулан, товлож бэлтгэсэн байна. Энэ нь, тайлбартай дасгал явуулах мөрдлөг асуултаа багш гаргаж бэлтгэнэ гэсэн үг юм. Тайлбартай дасгалын аргыг 1970-1985 –аад оны үед авиа зүй, үг зүй, өгүүлбэр зүйн задлалыг тайлбарлуулж байв. Гэтэл өнөөгийн үед яг ийм хэл зүйжилтэд хэт шүтэлгүйгээр, баяжуулан утга, найруулга, үг сонголт, эхийг задлах зэрэг өөр чөлөөт сэдвээр хийх хэрэгтэй. Харин хамгийн сайн хэрэгжүүлж болох салбар бол зөв бичих зүйн дүрэм, бичлэгийг тайлбарлуулах явдал юм. Тайлбарлуулах зүйлээ манай багш нар өөрсдөө сайн сонгож чадна ч, мэднэ ч.

Хэрэгжих шатлал

Нэг дэх шат: “Тайлбартай дасгалын арга”-аар хичээл явуулахад монгол хэлний хичээлээр бол яриа, бичгийн хосолмол дадлагын сайн суурь дээр хэрэгжүүлнэ. Математик, түүх, нийгэм, байгалийн ухаан зэрэг аль ч ерөнхий эрдмийн хичээл дээр сурагчийн ярих, бичих суурь чадварыг хөгжүүлэхэд эхлээд анхаарах нь чухал. Өөрөөр хэлбэл бусдад тайлбарлах, түргэн бичих явдал юм.

Хоёр дахь шат: Тайлбартай дасгал явуулах сэдвээр багш маш сайн мэдлэг олгосон, хүүхэд бүр баттай ойлгосон байх учиртай.

Гурав дахь шат: Тайлбарлаж хараахан чадахгүй хүүхэдтэй багш хичээлийн бус цагаар жич ажиллан бусдынх нь хэмжээнд хүртэл тус дэм үзүүлж, зарчим нь адил ч хялбар даалгавар өгч бэлтгэнэ.

Дөрөв дэх шат: Багш хэрхэн тайлбарлангаа бичих аргыг нийт хүүхдэд хэд хэдэн удаа тайван хийж үзүүлнэ. Дараа нь сайн тайлбарладаг хэд хэдэн хүүхдийг түр нэг доор суулган, бусдад үлгэрлэн тайлбарлуулж үзүүлнэ.

Тав дахь шат: Ангийн олонх хүүхэд бичингээ тайлбарлаж чадах болоод ирэх үед суудлын дарааллаар бүгдийг цувуулан тайлбартай дасгалаа явуулж эхэлнэ. Тайлбарлагч хүүхэд түгдрэх, буруу ярихад хүрвэл дараах хүүхэд “тайлбарлах эрхийг нь булаан авах дүрмийн дагуу” залган авч тайлбарлана. Эрхээ хэдэн удаа алдсан хүүхэд дараа мэрийж чадахын төлөө мэрийх болдог, бие даан бэлтгэл хийж эхэлснээр сайжирдаг. Энэ нь нэг хэсэгтээ ТДА-аар ангиараа хэвших эхний хэсэг юм.

Зургаа дахь шат: ТДА-аар ажиллаж сургахад, бага бүлэг буюу багаар гэрээрээ хүүхдүүд бие биедээ зааж өгөх дадлага хийж, хичээл дээр үр дүнгээ харна.

Дүгнэлт

“Тайлбартай дасгалын арга”, “Зөв, сайхан бичихэд сургах арга”-ыг хөгжүүлэн уламжлуулах талаар яам, хүрээлэн, Багш нарын мэргэжил дээшлүүлэх институт, аймаг, нийслэлийн Боловсрол төвүүд, монгол хэлний багш бэлтгэдэг их, дээд сургуулийн заах аргын багш нар юу хийвэл зохилтой вэ?

А. Тайлбартай дасгалын арга”-ыг багш нарт эзэмшүүлэх тухайд

Энэ аргын уламжлалт арга технологийн дэгийг хадгалахын зэрэгцээ, түүнийг баяжуулан сайжруулж болно

- “Тайлбартай дасгал” судлалыг хөгжүүлэх, шинжлэх ухааны талыг нь гаргаж тавих, тайлбарлах, тодруулах
- Багш бэлтгэдэг сургуулиуд бага ба суурь боловсролоор ялгааг нь гаргах, магистрант, докторантын судалгааны сэдэв болгох
- Улсын хэмжээнд бага, суурь, бүрэн дунд боловсролын сургалтын хүрээнд уг туршлага, арга зүй, технологийг сурталчлах, нэвтрүүлэх, түгээн дэлгэрүүлэх ажил зохион байгуулах, төсөл хэрэгжүүлэхэд ч болохгүй зүйлгүй.
- Дунд сургуулийн багш нарын сургалт семинарт тусган оруулах, багш бэлтгэх сургуулиудын Монгол хэлний дидактикийн агуулгад тусган, зааж судлуулах, багшлах дадлагад хэрэглүүлэх
- ТДА-аар гарын авлага, зөвлөмжийг Булганы болон Хишиг-Өндрийн бага анги, монгол хэлний багш нар бичиж гаргах
- Заах арга зүйчид, дидактикийн багш нар эдгээр арга туршлагыг түгээн дэлгэрүүлж арга зүйг нь боловсруулан нийтэлж байх
- Сургалтын үндэсний хөтөлбөрийн арга зүйн чиглэл болон сурах бичигт арга зүйг нь аль нэг хэмжээгээр шингээж тусгах
- Багш нарын дунд “Тайлбартай дасгалын арга” хэрэглэн заах уралдаан, олимпиадыг сургууль, бүс нутагт зохиох зэрэг улсын хэмжээнд өргөжүүлэх, хөдөлгөөн өрнүүлэх
- Энэ бүхэнд яам, хүрээлэнгийнхээ дэмжлэгийг авах нь чухал.

- Булганы Хишиг-Өндрийн сургууль энэхүү “Тайлбартай дасгалын арга”-аар видео CD, DVD хичээлүүдийг бичиж түгээн, багш нарт оюуны хөрөнгө оруулалт, сургуулийнхаа санхүүг дэмжих бодлого барихад анхаарах нь чухал юм гэж би хувьдаа үзэж байгаа юм. Энэ үйл хэрэгт нь “Тайлбартай дасгалын арга”-ын өлгий нутаг болох Хишиг-Өндөр сумын засаг захиргааны байгууллага, Булганы Боловсролын төв байгууллага түлхэц дэмжлэг үзүүлэх нь зүйтэй болов уу.

Б. “Зөв, сайхан бичихэд сургах арга”-ыг багш нарт түгээн эзэмшүүлэх тухайд

- Аймаг, нийслэл, дүүрэг, сургуулиараа сурагчдыг алдаагүй, цэвэр сайхан бичихэд сургах талаар зорилт тавин, хэрэгжүүлэх зорилтуудын дэвшүүлэн тавьж, дорвитой ажил зохион байгуулах
- Дээр өгүүлсэн арга зүй, туршлагыг ажил болгохын тулд багш нарт сурталчлан, хэлэлцүүлгийг заах аргын нэгдэл, багт зохион төлөвлөгөөт ажлуудыг хийж, дүгнэх
- Зөв, цэвэр сайхан бичгийн уралдаан зарлан дүгнэж, амжилт гаргасан сургууль, хамт олныг сайшаан сурталчлах
- Амжилтын эзэн сургууль, анги дээр сургалт семинар, үзүүлэх хичээл, нээлттэй ажил зохион байгуулах
- Монгол хэлний сургалт хариуцсан арга зүйч, дидактикийн багш нар тусгай арга зүй, зөвлөмж боловсруулан хэрэгжүүлэх, дунд сургуулиудын хүрээнд хэрэгжүүлэх хөдөлгөөн өрнүүлэх зэрэг олон хэлбэрийн ажил хийж болох байна.

Ашигласан материал

- Гаадамба, Ш. (1998). “Га багшийн дурсамж”. Улаанбаатар
- Жагдал, С., Дашзэвэг, Ц. (2016). Тайлбартай дасгалын арга. Улаанбаатар
- Лувсанцэрэн, Б. (1968-2007). Хувийн архивын материал. Улаанбаатар
- МХУЗ-ын боловсролын цөм хөтөлбөр/Суурь боловсрол/. (2015). Улаанбаатар
- Оюун, Ц. (2016). Тайлбартай дасгалын арга, сургалт семинарын материал. Улаанбаатар
- Өлзийхутаг, Ц. (1989). Монгол хэл бичгийн хичээлийн олимпиад. Улаанбаатар